



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 53

Номгон

Аймгийн хэмжээнд 1000 сарлагийн уралдаан зохион байгуулж дэлхийн дээд амжилтыг алдаршуулдаг Геннисийн номд оруулахаар ирүүлсэн Эрдэнэцогт сумын иргэдийн саналыг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, аймгийн Нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 дугаар бүлгийн 3.105 дахь заалт, Эрдэнэцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 1000 сарлагийн уралдаан зохион байгуулж дэлхийн дээд амжилтыг бүртгэж алдаршуулдаг Геннисийн номд оруулахаар ирүүлсэн Эрдэнэцогт сумын иргэдийн саналыг сайшаан дэмжсүгэй.

2. Уралдаан зохион байгуулах бэлтгэлийг хангах ажлын хэсэг байгуулж, хугацааг тогтоож, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117013